



МОНГОЛБАНК
САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА

МОНГОЛБАНКНЫ САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБАНЫ НЭРЭМЖИТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БҮТЭЭЛИЙН УРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

**(Санхүүгийн мэдээллийн албаны дэргэдэх Хамтын ажиллагааны зөвлөлийн Судалгаа
дүн шинжилгээний ажлын хэсгийн хүрээнд)**

НЭГ. ЗОРИЛГО

Оюутнуудыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр судалгаа, эрдэм шинжилгээний бүтээл туурвихад уриалж сэдэлжүүлэх, бүтээлийг нь олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, бодлогын шийдвэр гаргалтад оролцох оролцоог нэмэгдүүлэхэд энэхүү эрдэм шинжилгээний бүтээлийн уралдааны зорилго оршино.

ХОЁР. СЭДВИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

- Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог сайжруулах;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо эдийн засаг, санхүүгийн салбарт үзүүлэх нөлөө;
- Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх;
- Санхүүгийн боловсрол мөнгө угаах эрсдэлд хэрхэн нөлөөлөх тухай;
- Компаенсийн нэгж, ажилтнууд удирдлагаас хараат бус байж, үүргээ биелүүлэх, тавигдах шаардлагын хууль эрх зүйн орчинг сайжруулах;
- Санхүүгийн байгууллага болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх нөлөөлөл;
- Санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн компаенсийн тогтолцоог сайжруулах;
- Олон улсад улс төрийн дэмжлэг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоонд хэрхэн нөлөөлдөг тухай
- ОХУ-ын эсрэг авч хэрэгжүүлж буй хориг арга хэмжээ Монгол Улсын санхүүгийн системд үзүүлэх нөлөө
- Санхүүгийн мэдээллийн “Финтел” холбоог байгуулсан бусад улс орнуудын сайн туршлага;
- Дотоодын болон олон улсын Улс төрд нөлөө бүхий этгээдийн нэгдсэн мэдээллийн санг хөгжүүлэх сайн туршлагыг судлах;

- Цахим гэмт хэрэг, луйвар, залиланг бууруулах оновчтой арга аргачлал;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр гарч буй дижитал шилжилт, түүний үүрэг оролцоо;
- Хиймэл оюун ухааны технологийн хэрэглээ нэмэгдэж байгаатай холбогдуулан мөнгө угаах эрсдэл;
- Кибер залилангаас үүдэлтэй хууль бус санхүүгийн урсгал;
- Хөрөнгө оруулалтын хөтөлбөрөөр иргэншил, оршин суух эрхийг буруугаар ашиглах гэмт хэрэг;
- Хуурамч мөнгөн тэмдэгттэй холбоотой мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхэд Хавала болон бусад ижил төстэй үйлчилгээ үзүүлэгчдийн үүрэг оролцоо
- Сэжигтэй гүйлгээг илрүүлэх үйл ажиллагааг сайжруулах нь;
- Ковид-19 цар тахалтай холбоотойгоор үүссэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэл;
- Үнэт цаасны зах зээлээр дамжуулан мөнгө угаах гэмт хэргийн эрсдэл;
- Краудфандинг ашиглан терроризмыг санхүүжүүлэх эрсдэл;
- Цахим орчин дахь залилах гэмт хэргийг бууруулах олон улсын сайн туршлага судлах;
- Рансомвер халдлагаар дамжуулан мөнгө угаах гэмт хэрэг;
- Хувь хүний мэдээллийг ашиглан мөнгө угаах эрсдэл;
- Хууль бусаар алт олборлох гэмт хэрэг;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис худалдаалах гэмт хэрэг, олон улсын чиг хандлага;
- Бэлэн мөнгөний хэрэглээг хязгаарлах нь;
- Худалдаанд суурилсан мөнгө угаах үйл ажиллагаатай тэмцэх;
- Виртуал хөрөнгийн салбараар дамжуулан мөнгө угаах гэмт хэргийн чиг хандлага;
- Байгаль орчны гэмт хэрэгтэй холбоотой мөнгө угаах явдал;
- Гадаад худалдаанд суурилсан мөнгө угаах явдал;
- Хуулийн этгээдээр дамжуулан мөнгө угаах явдал;
- Хөдөө орон нутагт байршилтай мэдээлэх үүрэгтэй этгээдийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо, эрсдэл, эмзэг байдал;
- Үндэстэн дамнасан, зохион байгуулалттай гэмт хэрэг;
- Монгол Улсад үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй холбоотой гарч болох эрсдэл;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой бусад сэдвүүд.

ГУРАВ. БҮТЭЭЛД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

3.1 Бүтээлийн агуулгын хувьд:

- Онол, арга зүйн үндэслэлтэй;
- Шинэлэг, оновчтой санал, санаачлага дэвшүүлсэн;
- Бодит мэдээлэл ашиглаж, баримтаар баталгаажуулсан;
- Бодит байдалд хэрэгжиж болохуйц;
- Бусдын ажлыг шууд хуулбарлаагүй;
- Судалгаанд ашигласан материалыг бүрэн дурдсан;
- Орчин үеийн шинэ арга, хэрэгслийг ашигласан байх;
- Асуудал дэвшүүлж, тодорхой шийдэл, дүгнэлт, зөвлөмжийн шийдэл гаргасан байх.

3.2 Оролцогчдын хувьд:

- Багаар оролцож болох бөгөөд гишүүдийн тоо 3-аас ихгүй байна.

3.3 Бичгийн стандарт:

- Илтгэл нь үсгийн фонт - Times New Roman /"Mon" өргөтгөлтэй фонт байж болохгүй/;
- Фонтын хэмжээ - 12;
- Мөр хоорондын зай - 1.5;
- Хуудас: дээд захаас 20 мм, доод захаас 20 мм, зүүн захаас 30 мм, баруун захаас 15 мм;
- Цаасны хэмжээ: А4;
- Судалгааны хураангуй хэсгийг бичсэн;
- Нүүр хуудсанд нэр, холбоо барих 2 утасны дугаар, и-мэйл хаяг, ажлын болон сургуулийн нэр, курс, мэргэжил, судалгааны ажлын нэрийг бичсэн;
- Үг үсгийн болон утга найруулгын алдаагүй;
- Гарчиг, хураангуй, удиртгал, судалгааны хэсэг, дүгнэлт ном зүй гэсэн үндсэн хэсгүүдийг багтаасан;
- Оюуны бүтээлийг зөвшөөрөлгүй хуулбарлаагүй (Иш татсан тохиолдолд тогтсон стандартыг баримтлах) байх.

ДӨРӨВ. УРАЛДААНЫ ҮЕ ШАТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

4.1 Нэгдүгээр шат: Зохион байгуулах комисс бүтээлийг 2023 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн 18:00 цаг хүртэл цахим хэлбэрээр хүлээн авч судалгааны ажлыг дүгнэнэ.

4.2 Хоёрдугаар шат: Санхүүгийн мэдээллийн алба болон шүүгч нараас бүрдсэн баг судалгаанд ирүүлсэн бүтээлийг шүүж, нэгдсэн дүнг гаргана.

4.3 Эцсийн шатанд шалгарсан бүтээлүүдийн хэлэлцүүлэгт тавигдах шаардлага:

- Илтгэлийн PowerPoint файлыг Санхүүгийн мэдээллийн албаны fiupolicy@mongolbank.mn хаягаар заасан хугацаанд ирүүлэх;
- Гарчиг, удиртгал, үндсэн хэсэг, дүгнэлт, ном зүй гэсэн хэсгүүдээс бүрдсэн байх;
- Санаагаа ойлгомжтой, цэгцтэй хүргэх;
- Асуултад оновчтой хариулах;
- Илтгэл тавих хугацаа: 15 минут.

ТАВ. ШАГНАЛЫН САН

- 1-р байр - Өргөмжлөл, 2 000 000 /Хоёр сая төгрөг/;
- 2-р байр - Өргөмжлөл, 1 500 000 /Нэг сая таван зуун мянган төгрөг/;
- 3-р байр - Өргөмжлөл, 1 00 000 /Нэг сая төгрөг/;
- Тусгай байр - Өргөмжлөл, мөнгөн шагнал;

ЗУРГАА. МАТЕРИАЛ ХҮЛЭЭН АВАХ

Хугацаа: 2024 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн 18:00 цаг хүртэл бүтээлийн хэвлэмэл 2 хувийг Монголбанкны бичиг хэрэгт, цахим хэлбэрээр fiupolicy@mongolbank.mn хаягаар хүлээн авна.

Материалыг цахим хаяг руу илгээхдээ оролцогчийн мэдээлэл (нэр, гар утас, цахим хаяг, сургуулийн нэр болон бусад), удирдагч багшийн мэдээлэл (нэр, гар утас, цахим хаяг) болон эрдэм шинжилгээний бүтээлийн нэрийг тодорхой бичиж илгээхийг анхаарна уу.

**Бага тойруу 3, 15160, Улаанбаатар, Монголбанкны “Д” байр
Санхүүгийн мэдээллийн алба
МОНГОЛБАНК**

Дэлгэрэнгүй мэдээллийг fiu.mongolbank.mn веб хуудаснаас
болон (976) 11-326161 11-326803 утсаар лавлана уу.